

(Төсөл)

..... аймгийн ..... сумын ..... багийн  
“.....” бэлчээр ашиглагч малчдын бүлгийн бүх гишүүдийн  
20.... оны ..... сарын ..... өдрийн хурлаар хэлэлцэж батлав.  
Хурлын тэмдэглэл № 1

## “.....” БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН ХЭСГИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Бэлчээр ашиглагчдын хэсэг (цаашид БАХ гэж товчлон нэрлэх)-ийн оноосон нэр:  
“.....”
- 1.2. БАХ-ийн байршил: .....аймгийн .....сумын .....  
баг
- 1.3. БАХ-ийн статус: Малчдын сайн дурын байгууллага
- 1.4. БАХ-ийн үүсгэн байгуулагдсан огноо: 20... оны ...дугаар сарын ...
- 1.5. БАХ-ийн үүсгэн байгуулалт: Иргэний хууль болон холбогдох бусад хууль  
тогтоомжийн дагуу малчид сайн дураараа нэгдэж, энэхүү бүлгийг байгуулсан болно.
- 1.6. Иргэний хуулийн 481,1-д заасанчлан БАХ-ийн хамтран ажиллах гэрээ нь энэхүү  
дүрэм болно.
- 1.7. БАХ-ийг үүсгэн байгуулагчдын бүртгэл, хурлын тэмдэглэлийг энэхүү дүрмийн  
салшгүй хэсэг болгож хавсаргав.
- 1.8. БАХ нь өөрийн бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж болно.
- 1.9. БАХ-ийн ахлагчийн нэр: .....
- 1.10. Харилцах утас: .....

### Хоёр. БАХ-ийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1. БАХ-ийн зохион байгуулалтын хэлбэр нь нутаг дэвсгэрийн зарчмаар үүсгэн  
байгуулсан, заавал гишүүнчлэл бүхий нэгж мөн.
- 2.2. БАХ-ийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт нь байгалийн бэлчээрийн байршил,  
хэмжээ, ашиглалтын нийтлэг ба тухайн БАХ-т хамаарах онцлогт тулгуурлана.
- 2.3. БАХ-ийн бэлчээрийн хэмжээ, заагийг сумын Засаг даргатай байгуулсан гэрээгээр  
баталгаажуулна.
- 2.4. Энэхүү дүрмийн 2.4-д дурьдсан нэгж нь тухайн БАХ-ийн гишүүн малчин өрхөөс  
бүрдсэн байна.
- 2.5. БАХ-ийн гишүүн өрхүүд нөхөрлөл, хоршоо, ТББ-ыг байгуулах саналаа БАХ-ийн бүх  
гишүүдийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл авна. Нэгжийн хаяг, байршлын мэдээлэлд  
БАХ-ийн нэрийг заавал тусгуулна.
- 2.6. БАХ-ийн бүрэлдэхүүний малчдын хэсэг үүсгэхдээ нутаг дэвсгэрийн ба сайн дурын  
зарчмыг баримтална.
- 2.7. БАХ-ийн бүрэлдэхүүний хэсэг нь зөвхөн энэхүү дүрмийг, харин нөхөрлөл, ТББ,  
хоршоо өөрийн байгууллагын дүрмээс гадна энэхүү дүрмийг давхар мөрдөнө.

- 2.8. БАХ нь байнгын үйл ажиллагаа явуулна.
- 2.9. БАХ нь өөрийн мэдлийн дундын сантай байна. Дундын сангийн үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

### **Гурав. БАХ-ийн зорилго, үнэт зүйл, үйл ажиллагааны чиглэл**

- 3.1. Эрх бүхий этгээд (сумын Засаг дарга, хөрш БАХ, хэсэг, өрх)-тэй зөвшилцөн тохиролцож тогтоосон зааг бүхий бэлчээрийг урт хугацаагаар зохистой ашиглах, БАХ, түүний бүрэлдэхүүний нэгжийн үйл ажиллагааг хамтын удирдлагын зарчмаар хангах, гишүүн өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.
- 3.2. БАХ-ийн үнэт зүйл нь **бэлчээр** болно.
- 3.3. БАХ-ийн үйл ажиллагааны чиглэл
  - 3.3.1. Бэлчээр ашиглалт, менежментийн бусад арга хэмжээг экологийн чадавхид тулгуурлан төлөвлөх, зохицуулах зарчмыг хэрэгжүүлэх;
  - 3.3.2. БАХ-ийн малчдын малын тоо, төрлийг бэлчээрийн даац, чадавхтай уялдуулан зохистой түвшинд байлгах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах;
  - 3.3.3. Сумын засаг даргатай байгуулсан гэрээ болон уламжлалт зохицуулалтын хүрээнд тогтоосон зааг бүхий бэлчээрийн төлөв байдлыг алдагдуулалгүйгээр урт хугацаагаар зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;
  - 3.3.4. БАХ нь үйл ажиллагааны ба бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөөтэй ажиллах;
  - 3.3.5. БАХ-ээс тухайн жилд хэрэгжүүлэх бэлчээрийн менежментийн арга хэмжээг БИНХ-аар уламжлуулан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухай бүр тусгуулж албажуулдаг байх;
  - 3.3.6. Төсөл хөтөлбөр, бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад гишүүдийг хамруулах, тэдний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх;
  - 3.3.7. Гишүүдээс сайн дурын үндсэн дээр нийлүүлсэн хувь хөрөнгөд тулгуурлан дундын сан үүсгэх, энэхүү дүрэм, дундын сангийн журманд заасан нөхцлөөр ашиглах, арвижуулах;
  - 3.3.8. Бэлчээрт байгаа худаг, усны эх үүсвэрийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хамтран зохицуулах;
  - 3.3.9. БАХ-ийн гишүүн өрхийн малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
  - 3.3.10. Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрээний үндсэн дээр хоршоо, бирж, ашигтай зах зээлд хамтран борлуулах;
  - 3.3.11. Шаардлагатай тохиолдолд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зарим ажлыг хамтран хийх;
  - 3.3.12. БАХ-ийн гишүүдийг ажлын байраар хангах, орлого нэмэгдүүлэх бусад үйл ажиллагааг эрхлэх;
  - 3.3.13. Орон нутгийн төр захиргааны байгууллага, хөрш БАХ/ хэсэг, малчид, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагатай хоёр талын ашиг сонирхолд нийцүүлэн үр ашигтай хамтран ажиллах;
  - 3.3.14. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөөц баялгийг зохистой ашиглах.

### **Дөрөв. БАХ-ийн удирдлага ба шийдвэр гаргалт**

- 4.1. БАХ нь бэлчээр ашиглалт, мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр хөрөнгийн эх үүсвэр босгох, хамтран хөрөнгө оруулах асуудлаар хоршсон удирдлагын зарчмыг баримтална.
- 4.2. Орон нутгийн төр захиргааны байгууллагын хүрээнд:
  - 4.2.1. Бэлчээр ашиглалтын гэрээгээр гишүүн өрхийн хэмжээнд хамтран ашиглах, бэлчээрийн менежментийн арга хэмжээ төлөвлөх;
  - 4.2.2. Гишүүдийн нийгмийн асуудал, иргэний холбогдолтой асуудлаар харьцах;
  - 4.2.3. Бэлчээрийн менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд орон нутгийн төсөв, хөгжлийн сангаас дэмжлэг авах;
- 4.3. Төсөл, түүний түнш байгууллагын түвшинд:
  - 4.3.1. Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх арга зүйн болон чадавхи бэхжүүлэх арга хэмжээ хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх;
  - 4.3.2. Бэлчээр ашиглалт, сайжруулалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээг БАХ-ийн түвшинд төлөвлөх, сумын төлөвлөгөө, арга хэмжээнд тусгахад төлөөллийн байгууллагаар дамжуулан хамтран ажиллах;
  - 4.3.3. Бэлчээр, мал аж ахуйн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн борлуулалт, нэвтрүүлэх үйлчилгээний чиглэлээр дэмжлэг авах, хамтран ажиллах;
  - 4.3.4. БАХ-ийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлэхэд хамтын удирдлагын зарчмыг баримтлах;
  - 4.3.5. Хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх хэлбэр нь БАХ-ийн бүх гишүүдийн хурал мөн.
  - 4.3.6. Бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргана. Үүнд:
    - 4.3.6.1. БАХ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулахтай холбоотой цаг үеийн асуудлаар шийдвэр гаргах;
    - 4.3.6.2. БАХ-ийн дүрэмд өөрчлөлт, нэмэлт оруулах;
    - 4.3.6.3. БАХ-ийн ахлагчийг сонгох, өөрчлөх;
    - 4.3.6.4. БАХ-ийн ахлагчид энэхүү дүрмийн заалтад нийцүүлэн төлөөллийн ба шийдвэр гаргах эрх олгох;
    - 4.3.6.5. БАХ-ийн ба БАХ-ийн ахлагчийн үйл ажиллагааг хэлэлцэх, үнэлэх/дүгнэх;
    - 4.3.6.6. БАХ-ийн бүрэлдэхүүний нэгж байгуулах гишүүдийн саналыг хэлэлцэх, зөвшөөрөл олгох;
    - 4.3.6.7. БАХ-ийн үйл ажиллагааны тодорхой чиглэлийг хариуцах, бараа бүтээгдэхүүн худалдан авах, нийлүүлэх, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах, үйлчилгээ авах асуудлаар гишүүдэд ажил үүрэг оногдуулах, хуваарилах;
    - 4.3.6.8. БАХ-ийн гишүүнээс гаргах, гишүүн шинээр элсүүлэх асуудлыг шийдвэрлэх;
  - 4.3.7. Бүх гишүүдийн хурлыг улирал бүр хийнэ. Шаардлагатай үед ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно. БАХ-ийн ахлагчийн саналаар болон бүх гишүүн өрхийн 50-иас доошгүй хувь нь санал гаргаснаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
  - 4.3.8. Бүх гишүүдийн хурлын ирц гишүүн өрхийн 50 ба түүнээс дээш хувийн төлөөлөл биечлэн оролцсоноор хүчин төгөлдөр болно,
  - 4.3.9. Бүх гишүүдийн хурлыг БАХ-ийн ахлагч даргалах ба ахлагчийн эзгүйд хуралд оролцож буй гишүүдийн саналаар аль нэг гишүүн даргална.
  - 4.3.10. Хурлаар хэлэлцэх асуудлын онцлог, гишүүдийн саналыг харгалзан хурлын тэргүүлэгч сонгож болно. Хурлын тэргүүлэгчийн тоо сондгой, гэхдээ 7 байна.

- 4.3.11. БАХ-ийн гишүүн эрх бүх гишүүдийн хуралд саналын нэг эрхтэй оролцоно. Төлөөллийн журмаар саналын эрх эдлэхгүй.
- 4.3.12. Бүх гишүүдийн хурлаас гарах шийдвэрийг ил санал хураалтаар хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батална. Гишүүдийн хүсэлтээр саналыг нууцаар хурааж болно.
- 4.3.13. Хурлаас тэмдэглэл гаргана. Зохих журмын дагуу бүрэн хөтлөгдсөн тэмдэглэлийг хүчинтэй баримт бичигт тооцно.
- 4.3.14. Бүх гишүүдийн хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн гишүүнийг дүрэмд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсонд тооцож болно.
- 4.3.15. Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх, шийдвэрлэх асуудлаар аль нэг гишүүн сонирхлын зөрчилтэй гэж өөрөө юм уу гишүүд үзсэн бол санал хураалтад оролцохгүй, оролцуулахгүй байж болно.
- 4.3.16. Хэлэлцэж буй болон шийдвэр гаргах асуудлаар сонирхлын зөрчилтэй гэж хурал даргалагч өөрөө илэрхийлсэн, эсвэл гишүүд үзвэл хурлыг өөр гишүүнээр даргалуулж болно. Хурал даргалуулах гишүүнийг хуралд оролцож байгаа гишүүдийн саналаар томилно.
- 4.3.17. Бүх гишүүдийн хурлын ирц, гаргасан шийдвэрийг хурлын тэмдэглэлд тусгах ба хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурснаар баталгаажна.

#### **Тав. БАХ-ийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага**

- 5.1. БАХ-ийн үндсэн эрх
  - 5.1.1. БАХ-ийн дүрэмд заасан зорилго, үйл ажиллагааг мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулалтын хүрээнд бие даан буюу бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
  - 5.1.2. Гишүүдийн эрх ашгийг хамгаалах;
  - 5.1.3. Бусад этгээдтэй харилцах, хамтран ажиллах.
- 5.2. БАХ-ийн үндсэн үүрэг, хариуцлага:
  - 5.2.1. БАХ өөрийн үйл ажиллагаанд ардчиллын зарчмыг удирдлага болгох;
  - 5.2.2. Гишүүд, тэдний гэр бүлийн болон харъяа баг, сумынхаа нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлж, түнш, хамтрагчидтай байгуулсан гэрээ, хэлцлийг биелүүлэх;
  - 5.2.3. Өөрийн аливаа үйл ажиллагаанд БАХ нь жендерийн оролцоо, мэдрэмжийг эрхэмлэх;
  - 5.2.4. БАХ нь үйл ажиллагаандаа нийтийн ба хувь хүний хариуцлагыг баримтлах;
  - 5.2.5. Буруутай үйлдэл, үйл ажиллагааны улмаас үүссэн аливаа хариуцлага, үүргийг тухайн этгээд зөвхөн өөрийн эд хөрөнгөөр хариуцах.

#### **Зургаа. БАХ-ийн ахлагчийн эрх үүрэг**

- 6.1. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт БАХ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохион байгуулах;
- 6.2. БАХ-ийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөх, зар хүргэх;
- 6.3. БАХ-ийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх, бүх гишүүдийн хуралд хэлэлцүүлэх;
- 6.4. БАХ-ны ажлын тайланг улирал бүрээр гаргаж бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;

- 6.5. Бүх гишүүдийн хурлаас тогтоосон чиглэл, шийдвэр, энэхүү дүрэм (4.4 дэх заалт)-ээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд БАХ-ийг төлөөлж бусад байгууллага, хувь хүн, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах талаар шийдвэр гаргах, гэрээ, хэлцэл байгуулах;
- 6.6. Дундын сангийн удирдлагыг хэрэгжүүлэх, зарцуулалтыг хариуцах;
- 6.7. БАХ-ийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг борлуулах, худалдан авах ажиллагааг гишүүдтэй хамтран зохион байгуулах, гүйцэтгэх;
- 6.8. БАХ, түүний гишүүд, хамтран ажиллагч байгууллага, түншийн ашиг сонирхолд үл нийцэх юм уу зөрчилдөхгүй бол төр захиргааны сонгуульт болон томилгоот үүрэг, албан тушаал хаших, бусад байгууллагын санхүүгийн бус ажил шууд эрхлэх удирдлагад сонгогдох.

### **Долоо. БАХ-ийн гишүүнчлэл, гишүүний эрх үүрэг**

- 7.1. БАХ-ийн гишүүнчлэл нь нээлттэй байна.
- 7.2. БАХ-ийн гишүүнчлэлийг өрхөөр тогтооно.
- 7.3. БАХ, түүний гишүүдийн хоорондын харилцаа нь Иргэний хууль болон энэхүү дүрмийн заалт, БАХ-аас бусадтай байгуулсан гэрээний дагуу зохицуулагдана.
- 7.4. Хувь хүнийг гэрээний үндсэн дээр БАХ-т байнгын албан тушаал, ажил эрхлүүлж болох ба БАХ-ийн гишүүний эрх эдлэхгүй.
- 7.5. БАХ-ийн гишүүний эрх
  - 7.5.1. Дундын сан, борлуулалтын гэрээ зэрэг БАХ-ийн эрх мэдлийн эх үүсвэр, зуучлалын чанартай үйлчилгээ, дэмжлэг авах;
  - 7.5.2. Өөрсдийн саналаар, сайн дурын үндсэн дээр БАХ-ийн дотор албан бус хэсэг, ТББ, хоршоо байгуулах. Энэ асуудлаар БАХ-ийн ахлагч, нөлөө бүхий гишүүдтэй зөвшилцсөн, бүх гишүүдийн хурлаас зөвшөөрсөн байх;
  - 7.5.3. БАХ-ийн дундын санд нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс үл хамааран бүх гишүүдийн хуралд саналын нэг эрх эдлэх;
  - 7.5.4. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах санал гаргах;
  - 7.5.5. Бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, бусад гэрээ хэлцэлтэй танилцах;
  - 7.5.6. БАХ ба түүний гишүүний хооронд маргаантай асуудал гарсан тохиолдолд бүх гишүүдийн хурлаар шийдвэрлүүлэхээр санал гаргах;
  - 7.5.7. Энэхүү дүрэмд заасан нөхцөл, шаардлагыг хангахгүй бол БАХ-ийн гишүүнээс гарах.
- 7.6. БАХ-ийн гишүүний үүрэг :
  - 7.6.1. БАХ-ийн үнэт зүйл, нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах;
  - 7.6.2. БАХ-ийн дүрэм, бүх гишүүдийн хурлын шийдвэрийг дагаж мөрдөх;
  - 7.6.3. Дундын санд оруулах хувь хөрөнгөө хугацаанд нь бүрэн нийлүүлэх;
  - 7.6.4. БАХ-ийн ба бусад гишүүдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх;
  - 7.6.5. Холбогдох хууль тогтоомж, БАХ-ийн дүрэмд заасан бусад үүргийг сахиж биелүүлэх.

### **Найм. БАХ-ийн гишүүнээс гаргах, БАХ-т гишүүн элсүүлэх**

- 8.1. БАХ-ээс гарах, БАХ-т гишүүнээр элсүүлэхдээ дараах зарчмыг баримтална.
  - 8.1.1. БАХ-ийн бэлчээрийг ашиглахгүй болсон тохиолдолд БАХ-ийн гишүүнээс гаргах асуудлыг авч үзнэ.
  - 8.1.2. БАХ-ээс гарсан тохиолдолд тухайн гишүүн өөрийн өвөлжөө, хаваржаа, хашаа саравч, худаг, бусад байгууламжийн эзэмшил, ашиглалт, байршилтай холбогдох асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ. Үүнд:

- 8.1.2.1. Гишүүнээс гарч буй өрх нь өөрийн хөрөнгөөр барьсан хашаа, хороогоо зарах буюу бусдад шилжүүлэхээр бол БАХ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
  - 8.1.2.2. БАХ-ийн гишүүн бус этгээдэд өвөлжөө, хаваржааг дур мэдэн түрээслүүлэхийг хориглоно.
  - 8.1.2.3. БАХ-ээс гарах гишүүн өрх нь гишүүн байх хугацаанд ноогдох аливаа үүрэг, өр, зээлээ бүрэн барагдуулсан байна.
- 8.2. БАХ-ийн гишүүн өрхөөс шинээр малчин өрх тасрах, гаднаас шинээр гишүүн элсүүлэхэд дараах зарчмыг баримтална.
- 8.2.1. Малчин өрх шинээр тасарсан болон шинээр гишүүнээр элсүүлэх өрхөд тавигдах шаардлага адил байна.
  - 8.2.2. Малчин өрх шинээр тасрах, шинээр гишүүнээр элсүүлэхэд бэлчээр, ус, шинээр өвөлжөө, хаваржаа барих газрын хүрэлцээ байгаа эсэхийг харгалзан БАХ-ийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, БИНХ-аар дэмжүүлж, СИТХ-аар шийдвэрлүүлнэ. Ингэхдээ бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, бэлчээр ашиглалтын гэрээ, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусган мөрдүүлэх зарчмыг баримтална.
  - 8.2.3. Шинээр гишүүн элсүүлэхдээ БАХ-ийн бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олон буюу 75.0 –аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд шийдвэрлэнэ.
  - 8.2.4. Шинээр элсэх өрх нь тухайн сумын харъяат байна. Энэ нь уг өрхийг БАХ-т гишүүнээр заавал элсүүлэх үндэслэл болохгүй бөгөөд элсүүлэх эсэхийг энэхүү дүрмийн 8.2.2-д зааснаар шийдвэрлэнэ.
  - 8.2.5. БАХ-ийн гишүүн өрхөөс тасарсан болон гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан өрх нь энэхүү дүрэм болон бэлчээр ашиглалтын гэрээтэй танилцаж, зөвшөөрсөн тухай бичгээр баталгаа гаргана.

### **Ес . БАХ-ын дүрэм зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага**

- 9.1. БАХ-ын дүрмийг хүндэтгэх шалтгаангүйгээр зөрчсөн тохиолдолд БАХ-ын хурлаар хэлэлцэн дор дурьдсан хариуцлага хүлээлгэж, зөрчлийг арилгах хугацааг тогтоон өгнө.  
Үүнд:
  - 9.1.1. Удирдах бүрэлдэхүүнд сонгогдох эрх эдлэхгүй байх;
  - 9.1.2. БАХ, сумын бэлчээр ашиглагчдын холбоо, төрийн байгууллага болон бусад эх үүсвэрээс олгогдох мөнгөн болон биет хөрөнгө оруулалт, тусламж дэмжлэгт хамрагдах эрх эдлэхгүй байх;
  - 9.1.3. Дундын хуримтлалын сангаас зээл авах эрх эдлэхгүй.

### **Арав. Бусад**

- 10.1. Энэхүү дүрэм нь БАХ-ийн гишүүд хүлээн зөвшөөрч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2. Шаардлагатай бол БАХ-ийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн энэхүү дүрмэнд өөрчлөлт оруулж болно.

**Дүрмийг хүлээн зөвшөөрсөн БАХ-ийн гишүүдийн гарын үсэг**

<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Гарын үсэг</b>	<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Гарын үсэг</b>
1			41		
2			42		
3			43		
4			44		
5			45		
6			46		
7			47		
8			48		
9			49		
10			50		
11			51		
12			52		
13			53		
14			54		
15			55		
16			56		
17			57		
18			58		
19			59		
20			60		
21			61		
22			62		
23			63		
24			64		
25			65		
26			66		
27			67		
28			68		
29			69		
30			70		
31			71		
32			72		
33			73		
34			74		
35			75		
36			76		
37			77		
38			78		
39			79		
40			80		